

**ТООН ГАРЫН ҮСГИЙН ГЭРЧИЛГЭЭ**  
**ЭЗЭМШИХ ГЭРЭЭ**

2019 оны ... сарын ...-ны өдөр

№ .../...

Улаанбаатар хот

Энэ гэрээ нь нэг талаас тоон гарын үсгийн гэрчилгээ /цаашид ТГҮГ гэх/ авч буй  
..... –ын ..... албан тушаалтай  
.....регистрийн дугаартай, .....-ны ....., нөгөө  
талаас “Үндэсний Дата Төв” УТҮГ-ын бүртгэлийн нэгж /цаашид “Бүртгэлийн нэгж” гэх/-ийн  
ажилтан **Баянбилэг** овогтой **Төрбат** нар /хамтад нь “Талууд” гэх/ Монгол Улсын хууль  
тогтоомжийн дагуу энэхүү гэрээг байгуулж байна.

**Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1 Энэхүү гэрээгээр Монгол Улсын “Цахим гарын үсгийн тухай” хууль,  
“Үндэсний Дата Төв” УТҮГ болон ..... –ын хооронд  
байгуулсан 2019 оны ... дугаар сарын ....-ны өдрийн .../... дугаар бүхий “Тоон гарын  
үсгийн гэрчилгээ олгоход хамтран ажиллах гэрээ” –ний дагуу  
..... –ны албан хаагчдад тоон гарын үсгийн гэрчилгээ олгоход  
Бүртгэлийн нэгж болон тоон гарын үсэг эзэмшигч төрийн албан хаагч /цаашид  
“Эзэмшигч” гэх/-ийн хооронд үүсэх харилцааг зохицуулна.
- 1.2 Тоон гарын үсгийг ердийн гарын үсэгтэй адил хэрэглэнэ.
- 1.3 Эзэмшигч нь энэ гэрээний хугацаанд хууль болон гэрээнд заасан нөхцөл журмын  
дагуу гэрчилгээг ашиглах, эзэмших үүрэг хүлээнэ.
- 1.4 Гэрээний хүчинтэй хугацаа 2 хүртэл жил байна.

**Хоёр. Бүртгэлийн нэгжийн эрх, үүрэг**

- 2.1 Гэрчилгээ авах өргөдөл гаргагч нь шаардлагатай материалуудыг бүртгэлийн нэгжид  
өгөөгүй тохиолдолд өргөдлийг цуцлах эрхтэй;
- 2.2 Бүртгэлийн нэгж нь эзэмшигчийн мэдээллийн нууцыг чандлан хадгалах үүрэгтэй;
- 2.3 Эзэмшигчийн хувийн мэдээллийг зөвхөн гэрчилгээ олгох зорилгоор ашиглах  
үүрэгтэй;
- 2.4 Гэрчилгээний мэдээлэлд авсан бүх баримт бичиг, Э-токен төхөөрөмжийг Цахим  
гарын үсгийн тухай хуулийн 29.2, 32 дугаар зүйлийн дагуу хамгаалах үүрэгтэй;
- 2.5 Эзэмшигчийн мэдээллийг хуулиар зөвшөөрөгдсөн эрх бүхий этгээдээс бусад  
гуравдагч этгээдэд өгөхийг хориглоно.

**Гурав. Эзэмшигчийн эрх, үүрэг**

- 3.1 Тоон гарын үсгийг хэрэглэх эрхтэй;
- 3.2 Гэрчилгээг хүчингүй болгох, түдгэлзүүлэх, сэргээлгэх тухай хүсэлт гаргах эрхтэй;

Гарын үсэг: .....

Гарын үсэг: .....

- 3.3 Гэрчилгээ авахад өөрийгөө таниулж баталгаажуулахад шаардлагатай бичиг баримтыг үзүүлэх, зөвхөн үнэн зөв мэдээлэл өгөх үүрэгтэй;
- 3.4 Тоон гарын үсгийн хувийн түлхүүр, Э-токенд хандах нууц үгийг нууцлан хадгалах, тоон гарын үсгийн гэрчилгээний ашиглалт болон аюулгүй байдалтай холбоотой бүх асуудлыг хариуцах үүрэгтэй;
- 3.5 Тоон гарын үсгийн гэрчилгээний хувийн түлхүүр болон түүнийг хадгалсан Э-токен төхөөрөмжийг гэсэн, алдсан, гэмтээсэн, эвдсэн болон ийм сэжиг таамаг илэрсэн даруй өөрийн байгууллагын бүртгэлийн ажилтнаар дамжуулан бүртгэлийн нэгжид хандах үүрэгтэй;
- 3.6 Тоон гарын үсгийн гэрчилгээний хувийн түлхүүр, нууц үг, Э-токен төхөөрөмжийг бусдад шилжүүлэн дамжуулахгүй байх үүрэгтэй;
- 3.7 Ажлаас халагдсан, албан тушаал салбар хэлтэс өөрчлөгдсөн, шилжсэн болон ажил үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон бусад тохиолдолд тухайн Э-токен төхөөрөмжийг байгууллагын бүртгэлийн ажилтанд хүлээлгэн өгөх үүрэгтэй;

#### **Дөрөв. Гэрчилгээг хүчингүй болгох**

- 4.1 Э-токен төхөөрөмжийг хаясан, гэсэн, алдсан, эвдсэн, нууц үгийг алдсан тохиолдлыг бүртгэлийн нэгжид мэдэгдсэн бол хүчингүй болгоно.
- 4.2 Тоон гарын үсгийн гэрчилгээний эзэмшигч албан тушаалтан ажлаас халагдах, албан тушаалтан өөрчлөгдөх болон байгууллага, хэлтэс нэгж татан буугдах, өөрчлөгдөх тохиолдолд гэрчилгээ эзэмшигч, байгууллагын бүртгэлийн ажилтан бүртгэлийн нэгжид мэдэгдсэн бол гэрчилгээг хүчингүй болгоно.

#### **Тав. Гэрчилгээг шинэчлэн авах**

- 5.1. Тоон гарын үсгийн гэрчилгээний хугацаа дуусахаас 1 сарын өмнө гэрчилгээгээ шинэчлэн авах хүсэлтийг бүртгэлийн ажилтнаараа дамжуулан албан бичгээр гаргана.
- 5.2. Хүчингүй болгосон гэрчилгээг дахин сэргээх боломжгүй. Цахим гарын үсгийн гэрчилгээ авах хүсэлт гаргаж дахин гэрчилгээ авна.

#### **Зургаа. Үйлчилгээ**

- 6.1 Тоон гарын үсгийн гэрчилгээ тээгч Э-токен төхөөрөмжийн хандах “Нууц үг”-ийг нийт 15 удаа буруу оруулсан тохиолдолд уг төхөөрөмжийн криптографи модуль аюулгүй байдлын үүднээс түгжигдэх ба энэ тохиолдолд бүртгэлийн ажилтнаараа дамжуулан бүртгэлийн нэгжид хандана.
- 6.2 Түгжээг тайлсны дараа шинээр “Нууц үг” олгоно.

#### **Долоо. Хариуцлага, Маргаан шийдвэрлэх**

Гарын үсэг: .....

Гарын үсэг: .....

- 7.1 Талууд гэрээний үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйгээс гэрээний нөгөө талд хохирол учирсан бол буруутай тал хохирлыг бие даан хариуцаж, бүрэн төлж барагдуулна.
- 7.2 Эзэмшигч тоон гарын үсгийг зориулалтын бус ашигласан, өөрийн буруутай үйлдлээс шалтгаалж хохирол үүсэх тохиолдолд хариуцлагыг бүрэн хариуцна.
- 7.3 Буруу, худал мэдээлэл өгсний улмаас үүсэх хохирлын хариуцлагыг эзэмшигч хүлээнэ;
- 7.4 Гэрээтэй холбогдсон асуудлаар үүссэн маргааныг талууд хэлэлцээрийн замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.
- 7.5 Хэрэв талууд маргааныг хэлэлцээрээр шийдвэрлэж чадахгүйд хүрвэл Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид зааснаар эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.

**Найм. Бусад**

- 8.1 Энэхүү гэрээг талууд гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 8.2 Гэрээг 2 хувь үйлдэж, талууд тус бүр нэг нэг хувийг хадгалах ба гэрээний хувь тус бүр хуулийн хүрээнд адил хүчин төгөлдөр байна.

**ТАЛУУДЫН ХАЯГ:**

Хаяг:	Хаяг:.....
Сонгинохайрхан дүүрэг, 1-р хороо,	.....
“Үндэсний Дата төв” УТҮГ-ын байр.	Утас: .....
Утас: 70180092	Цахим хуудас: .....
Факс:70180093	Цахим шуудан: .....
Цахим хуудас: <a href="http://www.datacenter.gov.mn">www.datacenter.gov.mn</a>	
Цахим шуудан: <a href="mailto:info@datacenter.gov.mn">info@datacenter.gov.mn</a>	

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

“Бүртгэлийн нэгж” –ийг төлөөлж:	Тоон гарын үсгийн гэрчилгээ эзэмшигч:
“Мэдээллийн аюулгүй байдлын хэлтэс”-ийн дарга:	.....-ны ..... албан тушаалтай:
...../ Б.Төрбат /	...../ .....

Гарын үсэг: .....

Гарын үсэг: .....